**ДУНДГОВЬ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 12 сарын 23 өдөр Дугаар А/258 Мандалговь

Олгойн говь-1 орд газарт шинээр гүний
худаг гаргаж, цахилгаан хангамж,
цэвэр усны дамжуулах шугамын ажлыг хүлээн
авах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журмын 4.3.4 дүгээр заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжиж буй Олгойн говь-1 орд газарт шинээр гүний худаг гаргаж, цахилгаан хангамж, цэвэр усны дамжуулах шугамын ажлыг хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | |
|---|---|
| Комиссын дарга: | Н.Эрдэнэ-Очир (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга) |
| Гишүүд: | М. Дашхүү (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн) |
| | Э.Энхмэнд (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын хэлтсийн дарга) |
| | Л.Пүрэвдорж (Топ дриллинг ХХК-ийн захирал) |
| Нарийн бичгийн дарга: | Д.Сэргэлэнбаатар (Дундговь-Ус Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын ерөнхий инженер) |

2. Олгойн говь-1 орд газарт шинээр гүний худаг гаргаж, цахилгаан хангамж, цэвэр усны дамжуулах шугамын ажлыг хүлээн авч, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн ажиллахыг комиссын дарга (Н.Эрдэнэ-Очир)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Л.ДОРЖБАТ

48 0150838